



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**



**Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэргийн гарч байгаа
шалтгаан нөхцлийг тогтоох чиглэлийн ажлуудыг
төлөвлөөгүй байна.**

2017 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Д.Оюунбат Ахлах аудитор Ц.Батсайхан 2017 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3156 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. Байгууллагын хаяг: ГСА Сүмбэр сум 3-р баг, Нутгийн удирдлагын ордон 2-р давхар б корпус 208 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Бүлэг 1.1 Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна. 1.1.1. Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүрэг хууль тогтоомжийн дагуу явагдаж байна. 1.1.2. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн жил бүрийн ажлын төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна. 1.1.3. Захиргааны хяналт тогтоосон иргэдийн 6.6 хувь нь дахин гэмт хэрэгт холбогдсон байна. 1.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулах ажил тогтмолжсон байна. 1.1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах ажил жил бүр хийгддэг боловч үр дүнг тооцох асуудал дутагдалтай байна. Бүлэг 1.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр нь голлон сургалт сурталчилгаа хийхэд чиглэгдсэн байна. 1.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр нь голлон сургалт сурталчилгаа хийхэд чиглэгдсэн байна. 1.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд Цагдаагийн байгууллагын зарим чиг үүргийг орхигдуулсан байна. 1.2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг тооцох үйл явц, үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна. Бүлэг 1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. 1.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг жил бүр 2,079.5-34,511.0 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.
--	---

1.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 дэх заалттай нийцэхгүй байна.

1.3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад хууль болон журмаар зохицуулагдсан байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд хийсэн тайлбар

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн ҮАГ-ын ГАГ-ын нэгдсэн удирдамжийн дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт

Аудитаар Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх

3. Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн ИТХ, Прокурор болон Цагдаагийн газар, бусад холбогдох төрийн байгууллагуудын ажлын тайлан, аймгийн ГХУСАЗСЗ-ийн болон ГХУС зардлын 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн баримт, мэдээ судалгаа, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлага, бусад материалуудыг хамрууллаа.

4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

5. Үндсэн мэдээлэл:

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, тус зөвлөлийн ажиллах журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 2015 онд 20,300.0 мянга, 2016 онд 28,661.5 мянга, 2017 онд 50,283.4 мянган төгрөг тус тус зарцуулахаар баталж, 2015 онд 7,554.5 мянга, 2016 онд 28,661.5 мянга, 2017 оны эхний хагас жилд 33,143.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна

5. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Оюунбат, Ц.Батсайхан нар хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

Аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан баталгаажууллаа.

Бүлэг 1.1

Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна.

1.1.1. Гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиг үүрэг хууль тогтоомжийн дагуу явагдаж байна.

Говьсүмбэр аймагт ГХУСАЗСЗ нь анх 2001 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 18 дугаар тогтоолоор 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХТ-ийн 2016 оны 79 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан байна.

Зөвлөлийг хуулийн дагуу аймгийн ИТХ-ын дарга удирдан зохион байгуулж байгаа бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд /Прокурор, Цагдаа, Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар, Боловсрол, соёл урлагийн газар, ХГБЗХГ, Авто тээврийн төв, АГХУСАЗСЗ-ийн мэргэжилтэн, Иргэний нийгмийн байгууллага, иргэний төлөөлөл/ зэрэг 11 байгууллагын төлөөллүүд багтаж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь жил бүр хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодорхойлсон дүгнэлт, таницуулгын дагуу ажлаа төлөвлөж явуулдаг бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж ирсэн байна.


Цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн даргаар ахлуулсан 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй баг гэмт хэрэг, зөрчлийн байдалд судалгаа, шинжилгээ хийж, гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг тодорхойлдог байна.

Дээрх бүрэлдэхүүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээний ахлах мэргэжилтэн, мэдээлэл сурталчилгааны ахлах мэргэжилтэн, хэв журмын ахлах мэргэжилтэн, мөрдөн байцаах тасгийн ахлах мэргэжилтэн, замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, эрүүгийн төлөөлөгч нар багтаж байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 133 холбогдогчтой, 248.0 сая төгрөгийн хохиролтой, 139 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс гэмт хэрэг 16 буюу 10.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Аймгийн Цагдаагийн хэлтсээс гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодорхойлсон байдлыг 2017 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

1. Гэмт хэргийн гаралтыг төрлөөр нь авч үзвэл:




Графикаас харахад: Өмнөх оны мөн үеэс бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 61 бүртгэгдсэн нь 9 хэргээр буюу 12.8 хувь, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 50.0 хувь, бусдын эд хөрөнгийг завшиж үрэгдүүлэх гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 3 хэргээр буюу 60.0 хувь, танхайрах гэмт хэрэг 3 бүртгэгдсэн нь 3 хэргээр буюу 50.0 хувиар, хүчин 1 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 60.0 хувиар тус тус буурсан байна.

Мал хулгайлах гэмт хэрэг 15 бүртгэгдсэн нь 9 хэргээр буюу 2 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 15 бүртгэгдсэн нь 7 хэргээр буюу 87.5 хувиар, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 39 бүртгэгдсэн нь 2 хэргээр буюу 5.4 хувиар тус тус өссөн байна.

2. Гэмт хэрэг гарсан газруудаар нь авч үзвэл:

Гэмт хэрэг гарсан газар




Графикаас харахад: Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 5-аар буюу 16.6 хувь, гэр орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 10-аар буюу 20.0 хувь, төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 6-аар буюу 60.0 хувь, төрийн бус байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 1 нэгжээр, аж ахуйн нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 6-аар буюу 54.0 хувь, бусад газар үйлдэгдсэн гэмт хэрэг 1-ээр буюу 3.2 хувиар тус тус буурчээ.

Олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 5-аар буюу 45.0 хувь, авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 7-оор буюу 87.5 хувь, нийтийн тээвэрт үйлдэгдсэн гэмт хэрэг 3-аар буюу 75.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3. Гэмт хэргийг гарсан цаг хугацаагаар нь авч үзвэл:

Гэмт хэрэг гарсан цаг



Графикаас харахад: Бүртгэгдсэн гэмт хэргийн 22-06 цагийн үед 57 нь буюу 17.9 хувь, 06-14 цагийн үед 31 буюу 6.1 хувь, 14-19 цагийн үед 27 буюу 27 хувиар тус тус буурч 19-22 цагийн үед 24 буюу 33 хувиар өссөн байна.

4. Гэмт хэрэг гарсан шалтгаанаар нь авч үзвэл:



Графикаас харахад: Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаас үзэхэд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 17-оор буюу 30 хувь, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 7-оор буюу 28 хувь, бүлгээр үйлдсэн гэмт хэрэг 8-аар буюу 40 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 3-аар буюу 50 хувь, хүүхэд оролцсон гэмт хэрэг 9-өөр буюу 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд 2017 оны эхний 9 сард 12,983 захиргааны зөрчил илрүүлэн шалгасан нь урьд оны мөн үеэс 2,275 зөрчлөөр буюу 21.2 хувиар өссөн байна.

Нийт зөрчил гаргасан 12,833 хүнийг 379,987.0 мянган төгрөгөөр торгож, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 92 жолоочийг торгож тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасч, 56 хүнийг захиргааны зөрчлийн улмаас сум дундын шүүхэд материалыг хүргүүлэн 7-30 хоногоор баривчлуулан захиргааны хэмжээ авч 476 иргэн зөрчлийн улмаас эрүүлжүүлэгдсэн байна.

Цагдаагийн хэлтэс нь өмнөх саруудад гэмт хэргийн гаралт өссөн үзүүлэлтүүдэд голлон анхаарч ажилладаг бөгөөд нийт гэмт хэргийн гаралтаар малын хулгай болон зам тээврийн хэрэгслэлтэй холбоотой гэмт хэрэг ихэнх байр суурийг эзэлсэн байна.

Энэ нь Улаанбаатар, Говьсүмбэр аймгийг холбосон хатуу хучилттай зам дагуу үйлдэгддэг бөгөөд малыг хараа хяналтгүй орхидог, замын эвдрэл гэмтэл, жолооч нарын хурд хэтрүүлэлт, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэх зэргээр тодорхойлсон байна.

Аймгийн Прокурорын газар нь жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө ГХУСАХ-г төлөвлөхийн зэрэгцээ аймгийн ерөнхий Прокурорын баталсан удирдамжийн дагуу ГХУС чиглэлээр тусгайлсан шалгалтыг зохион байгуулан ажиллаж ирсэн байна. Тухайлбал: гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2015 онд 4, 2016 онд 4, 2017 онд 13 ажил төлөвлөж, тухайн онуудад нийтдээ 11 тусгайлсан удирдамжийн дагуу 21 байгууллагад хяналт шалгалт хийсэн байна.

Прокурорын газар нь гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцлийн талаар 2015-2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 550 эрүүгийн хэрэгт хяналт

тавьсанаас 8.4 хувь буюу 46 хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай мэдэгдэл бичиж, хэрэгжилтийг хангуулж ажилласан байна.

Шалгалтын хүрээнд илэрсэн зөрчил, хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулахаар 2015 онд прокурорын 12 мэдэгдэл бичиж, 19 удаа 904 хүнийг хамруулан ухуулга сурталчилгаа, ярилцлага зохион байгуулж, хэвлэлд 6 мэдээлэл нийтлүүлсэн, 2016 онд төлөвлөгөөнд тусгагдсан 5 шалгалтыг дангаараа хийж, шалгалтын дүнг 4 удаа байгууллагын вэб сайтад тавьж, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийн талаар 18 мэдэгдэл хүргүүлж, хариуг авсан ба гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 17 удаа яриа таниулга хийсэн байна. Мөн Сүмбэр сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх аян”-ыг зохион байгуулж, тус сумын 25 иргэнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийсэн байна.

2017 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлаас 10 шалгалт судалгаа хийж, аймгийн телевизэд 2, байгууллагын вэб сайтад 12 материал тавьж, нийт 14 удаа сургалт, сурталчлагаа зохион байгуулсан байна. Шалгалт, судалгааны хүрээнд гарсан шалтгаан нөхцлийг арилгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах тухай нийт 16 мэдэгдэл бичиж, хариуг авч ажилласан бөгөөд дангаараа 5, хуулийн байгууллагуудтай хамтран 4 удаа 3 суманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчлах, яриа таниулга хийсэн байна.

Прокурорын газрын дүгнэлтэд гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдийн хувийн зан чанар, ахуй амьдралын нөхцөл байдал, боловсрол, ухамсар зэрэг нөлөөлснөөс гадна архидан согтуурах, ажилгүйдэл зэрэг нийгмийн шинж чанартай хүчин зүйлүүд нөлөөлж байгааг тодорхойлсон байна.

Аймаг болон сумдын ГХУСАЗСЗ-өөс хууль сахиулах байгууллагуудаас ирүүлсэн мэдээ тайланд үндэслэн гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцлийг судалж, дүн шинжилгээ хийсэн судалгаа, тоо баримт, тайлан мэдээ байхгүй байна.

1.1.2. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн жил бүрийн ажлын төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл нь жил бүр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв хөрөнгийг төлөвлөн аймгийн ГХУСАЗСЗ-ийн анхдугаар хурлаар хэлэлцэн баталж ирсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015-2017 онд хийсэн ажлын төлөвлөгөө дараах байдалтай байна.

/мянган төгрөг/

№	Он	Төлөвлөсөн	
		Арга хэмжээний тоо	Зарцуулах төсөв
1	2017 он	41	25,100.0
2	2016 он	27	30,000.0
3	2015 он	35	17,890.0

Хүснэгтээс харахад: ГХУСАХ-нд зарцуулах төсвийг 2016 онд өмнөх оноос 67.7 хувиар нэмэгдүүлсэн бол 2017 онд өмнөх оноос 16.3 хувиар бууруулан баталсан байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлыг төлөвлөхдөө зөвхөн ГХУСАЗСЗ-ийн гишүүн 8 байгууллагын саналыг авч байгаа нь хангалтгүй байна.

Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг авдаг боловч нэгтгэж аймгийн хэмжээний төлөвлөгөө боловсруулаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд голлож нийтийг хамарсан уралдаан тэмцээн, зөвлөгөөн, аян, сургалтуудыг явуулахаар төлөвлөсөн байна. Энэ нь гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлж, сургалт сурталчилгааны ажлыг хийдэг боловч гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийдэггүй, цаашид гэмт хэргийг бууруулах урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулсан ажил хангалтгүй, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой асуудлууд тусгагдаагүй байна.

2014-2015 ондуудад ихэнх аж ахуй нэгж, байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөгүй байсан бол 2016 оноос нийт аж ахуй нэгж, байгууллагын 80-аас дээш хувь нь төлөвлөдөг болсон байна.

Энэ талаар 2015 онд аймгийн ГХУСАЗСЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу 2014 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сумдын ГХУСАЗСЗ-үүд шалгаж, аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуралд танилцуулсан бөгөөд жил бүр ажлын үр дүнг шалгах ажлыг төлөвлөдөг боловч энэ ажил 2016 онд хийгдээгүй байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь өмнөх онд хэрэгжээгүй ажлын нөхцөл байдлыг тодорхойлж дараа оны төлөвлөгөөнд хамруулах ажил хангалтгүй байна. Тухайлбал: 2015 онд 3 арга хэмжээ, 2016 онд 2 арга хэмжээ хэрэгжээгүй байхад дараа оны ажлын төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Цаашид сумдаас болон аж ахуйн нэгж, байгууллагуудаас авсан ажлын саналыг нэгтгэж, аймгийн хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Гэмт хэрэгт холбогдсон иргэнийг хууль хяналтын байгууллагуудын хяналтанд байх хугацаанд тэднийг нийгэмшүүлэх, хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмшүүлэх талаар аймгийн Хөдөлмөр халамжийн газар, Политехникийн коллеж, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран ажилладаг боловч хяналтаас гарсан тохиолдолд тэдгээрт тавих хяналт байхгүй байна.

Аймгийн хэмжээнд “АА”-ын 6 бүлэг ажилладаг бөгөөд долоо хоногт 3 удаа цугларч жилдээ дунджаар 60-70 хүн хамрагдаж байгаа нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тодорхой үр нөлөө үзүүлж байна.

2015-2017 оны ажлын төлөвлөгөөнд эрх зүйн чиглэлээр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх зөрчлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Тамхины хяналтын тухай хууль, Архидан согтууралтай тэмцэх тухай хуулиудыг сурталчлах ажлуудыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөж ирсэн байна.

1.1.3. Захиргааны хяналт тогтоосон иргэдийн 6.6 хувь нь дахин гэмт хэрэгт холбогдсон байна.

Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэс нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналтыг тогтоох ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

2015-2017 онд захиргааны хяналт тогтоосон байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	2017 оны эхний хагас жил		2016 он		2015 он	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Захиргааны хяналт тогтоогдсон хүний тоо	34	100	29	100	32	100
2	Захиргааны хяналт тогтоогдсон хүнээс ажилд орсон	6	17.6	6	20.7	4	12.5
3	Захиргааны хяналт тогтоогдсон хүнээс дахин хэрэгт холбогдсон	0	0	2	6.9	2	6.25

Хүснэгтээс харахад: 2015 онд 32 хүнд захиргааны хяналт тогтоосноос 12.5 хувь буюу 4 нь ажилд орж, 6.2 хувь буюу 2 нь дахин хэрэгт холбогдож байсан бол 2016 онд 29 хүнд захиргааны хяналт тогтоосноос 20.7 хувь буюу 6 нь ажилд орж, 6.9 хувь буюу 2 нь дахин хэрэгт холбогдож байсан байна.

Дахин гэмт хэрэгт холбогдож байгаа иргэд нь бүртгэлд хамрагдаагүй, үүргээ бүрэн ухамсарлаагүй, өөр аймагт түр ажиллаж, амьдрах зэрэг шалтгаанаар хаяг тодорхойгүй, холбоо барих боломжгүйгээс хяналтаас гарч гол төлөв дахин гэмт хэрэгт холбогдсон байна. Энэ нь Цагдаагийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо, мэдээлэл солилцох системийг боловсронгуй болгох, сайжруулах шаардлагатайг харуулж байна

2017 оны 3 дугаар улирлын байдлаар 34 хүнд захиргааны хяналт тогтоосноос 17.6 хувь буюу 6 нь ажилд орж, дахин хэрэгт холбогдсон хүнгүй байна.

Хорих ял эдлээд суллагдсан иргэнд захиргааны хяналтыг тогтоох ажил хууль тогтоомжид заасны дагуу явагдаж байна. Тухайлбал: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасны дагуу хорих байгууллагаас сулладагч этгээдийн оршин суух газрын хаягийг Цагдаагийн байгууллага түүнийг суллагдах тухай материал хүлээн авсан даруй мэдээллийн нэгдсэн санд бүртгэн авч сар бүр үүрэг чиглэл, зөвлөгөө өгч ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасны дагуу хорих ял эдлээд суллагдсан этгээд оршин суух газрын хаягаа Цагдаагийн байгууллагад 3 хоногийн дотор бүртгүүлэх, 15.7.1-т заасны дагуу тухайн иргэний зан төрх, аж байдлын талаар багийн Засаг дарга нарын тодорхойлолтыг авч хувийн хэрэгт баяжилт хийх зэрэг ажлууд хууль тогтоомжийн дагуу явагдаж байна.

2016 онд Захиргааны хяналтад байх хугацаандаа зөрчил гаргасан 3 ялтныг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9-т заасны дагуу ялыг өөрчлүүлэх саналыг Шүүхэд гарган шийдвэрлүүлсэн байна.

Захиргааны хяналт тогтоох ажил хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа хэдий ч 2015-2016 онд нийт 4 иргэн дахин хэрэгт холбогдсоноос үзэхэд хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

Цагдаагийн хэлтсээс хяналт зогсоох тухай тогтоолыг үйлдэж, Прокурорын байгууллагаар хянуулан Цагдаагийн хэлтсийн нэгдсэн санд хааж байна.

1.1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулах ажил тогтмолжсон байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасны дагуу 2016 оны 10 дугаар сараас эхлэн “Олон нийтийн эргүүл” хийх хуваарийг аймгийн ИТХ-ын даргын захирамжаар батлуулан мөрдөж ажилласан байна.

Энэ арга хэмжээ нь зөвхөн аймаг, Сүмбэр сумын хэмжээнд хийгддэг бөгөөд цаашид бусад сумдад хэрэгжүүлэх шаардлагатай байна.

2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 31 хүртэлх хугацаанд нийт 75 аж ахуйг нэгж, байгууллага болон төрийн бус байгууллагуудын 220 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдан олон нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, илтгэх хуудсаар баталгаажуулсан байна.

Мөн сургуулиудаас зохион байгуулж буй “School police” нэртэй эргүүлийг хуваарийн дагуу эцэг эхчүүд сургуулийн ойр орчимд эргүүл хийх ажил тогтмолжсон байна.

Эргүүлийн ажлыг Цагдаагийн хэлтсээс мэргэжлийн хүн удирдаж ажилладаг бөгөөд эргүүлийн баг аж ахуйн нэгж байгууллагуудын харуул манаа, зочид буудал, дэлгүүр, оюутны байр, шатахуун түгээх газар, РС, биллъярд тоглоомын газрууд, вагон ирэх, явах цагуудаар эргүүл хийж, гарсан зөрчилд тухай бүр арга хэмжээ авч ажилласан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоо, идэвхийг сайжруулснаар аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд гэмт хэрэг 2.5-10.6 хувиар буурахад нөлөөлсөн байна. Хууль, цагдаагийн байгууллагаас иргэд, олон нийтэд тэр бүр хүрч ажиллах боломжгүй бөгөөд гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл өгөх хамгийн боломжит оролцогч бол иргэд юм.

Иргэд, ААНБ-аас мэдээлэл, санал авах байдлаар иргэдийг татан оролцуулж байгаа хэдий ч гэмт хэргийн талаар иргэдээс төлбөртэй мэдээлэл авах ажил хангалтгүй байна. Иргэдээс гэмт хэргийн талаарх мэдээллийг төлбөртэй авснаар ГХУС ажилд оролцох иргэдийн идэвх нэмэгдэх хөшүүрэг болохоор байна.

1.1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах ажил жил бүр хийгддэг боловч үр дүнг тооцох асуудал дутагдалтай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн талаар сургалт, сурталчилгаа, яриа таниулга хийх, гарын авлага, боршур тараах, телевиз, хэвлэл мэдээлэл, цахим ашиглах зэрэг хэлбэрүүдээр явуулж ирсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тоо, мэдээг иргэд олон нийтэд ил тод мэдээлдэггүй, зөвхөн ГХУСАЗСЗ-ийн хэмжээнд тайлагнагдаж байна.

ГХУСАЗСЗ-ийн 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийгдсэн ажлын тоо мэдээний судалгааг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэр	2017 оны эхний хагас жил		2016 он		2015 он	
		Удаа	Хамарсан хүний тоо	Удаа	Хамарсан хүний тоо	Удаа	Хамарсан хүний тоо
1	Сургалт, сурталчилгаа	58	2,933	118	8,799	96	2,880
2	Яриа, таниулга	17	1,600	26	3,700	18	2,800
3	Гарын авлага, боршур	13	3,457	28	4,200	26	3,900
4	Телевизээр	26		37		29	
5	Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр	5		13		8	
6	Цахим хэлбэрээр	75		144		114	

Хүснэгтээс харахад: 2016 оныг өмнөх онтой харьцуулахад сургалт, сурталчилгаа 22 удаа буюу 5,919 хүн, яриа таниулгад 18 удаа 900 хүн, гарын авлага боршур 2 удаа гаргаж, 300 хүнээр тус тус өссөн байна. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах ажил тоон үзүүлэлтийн хувьд нэмэгдсэн хэдий ч үр дүнг нэгтгэж дүгнэх асуудал дутагдалтай байна

2017 оны эхний хагас жилийн байдлаар сургалт, сурталчилгааг 58 удаа 2,933 хүн, яриа таниулга 17 удаа 1,600 хүн, гарын авлага брошур 13 удаа 3,457 хүнийг тус тус хамруулан, телевизээр 26, хэвлэл мэдээлэлээр 5, цахим хэлбэрээр 75 удаа мэдээлэл явуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төлөвлөсөн ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд сургалт, сурталчилгаа нилээд явуулдаг боловч аймгийн хэмжээнд нэгтгэсэн тоо мэдээ байхгүй, үр дүнг тооцоогүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй байна уу ?

Бүлэг 1.2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр нь голлон сургалт сурталчилгаа хийхэд чиглэгдсэн байна.

1.2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр нь голлон сургалт сурталчилгаа хийхэд чиглэгдсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг хуульд заасан арга хэлбэрээс гадна нь сургалт, зөвлөгөөн, яриа таниулга хийх, хяналт шалгалт зохион байгуулах, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр зохион байгуулж гэмт хэргийн гаралтыг бууруулахад нөлөө үзүүлэн ажиллаж байна.

ГХУС чиглэлээр жил бүр хөтөлбөр боловсруулан аймгийн ОНХС-аас зардлыг санхүүжүүлж ирсэн боловч хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг тооцож, үнэлэлт дүгнэлт өгөх ажил дутагдалтай байна.

Аймгийн ГХУС ажил нь дээрх арга хэлбэрүүдээр зохион байгуулагдаж байгаа нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлж чадахгүй байна. Иймд дараах арга хэмжээг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Бүх шатны Засаг дарга нартай ажлын уялдаа холбоогоо сайжруулах
- Жил бүр тодорхой зорилт дэвшүүлэн тусгайлсан аяныг зохион байгуулах
- Олон нийтийн цагдаа нарын ажлын үр дүнг нэмэгдүүлэх
- Аймаг, сумдыг камтержуулалтын системд шилжүүлж, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангах
- Гудамж талбайн гэрэлтүүлгийн ашиглалтыг сайжруулах, шөнийн цагаар ажиллуулах цагийг уртасгах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог зөвхөн эргүүл хийх төдийгөөр хязгаарлалгүйгээс өргөн хүрээтэй авч үзэх, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч ажлын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, урамшуулдаг байх
- Сумдад ГХУС тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага арга зүйгээр хангаж ажиллах, сумдын мэдээ тайланг нэгтгэн хянах
- Аймаг, сумдын хэмжээнд ГХУС чиглэлээр хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнг тооцож, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах

1.2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд Цагдаагийн байгууллагын зарим чиг үүргийг орхигдуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтад Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын үүргийг тусгахдаа Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоон, арилгуулах, 10.1.2-т “гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээн авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээг авах, гэмт хэргийг илрүүлэх” гэсэн хуулийн заалтуудыг орхигдуулсан байна.

Мөн 2015-2017 онуудад ГХУСАЗСЗ-ийн төсвийг ИТХ-ын дарга өөрөө хуваарилж, зарцуулж гүйцэтгэж ирсэн нь хуулийн дагуу хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болгосон байсан.

1.2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг тооцох үйл явц, үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.

Аймгийн ГХУСАЗСЗ нь 2015 онд 4 бүлэг 35 заалт, 2016 онд 4 бүлэг 27 заалттай төлөвлөгөө баталсан боловч төлөвлөгөөний хэрэгжилтийг заалт тус бүрээр гаргаж тайлагнаагүй, жилийн эцэст ажлын тайланг зөвлөлийн хурлаар хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөөгүй, хурлын тэмдэглэлээр баталгаажуулаагүйгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцох боломжгүй байна. Үүний улмаас ГХУС ажил бүрэн хэрэгжихгүй, зорилтот үр дүндээ хүрэхгүй байх үр дагавартай байна

Мөн 2017 онд 4 бүлэг 41 заалттай төлөвлөгөө баталсан боловч төлөвлөгөөний хэрэгжилийг хагас жилийн байдлаар гаргаж дүгнээгүй байна.

Тус зөвлөлд сумдын зөвлөлөөс ГХУС ажлын тайланг улирал бүр ирүүлсэн байна. Мөн ГХУСАЗСЗ нь ажлын тайланг гишүүн байгууллагуудаас авахдаа төлөвлөгөөний биелэлтээр авдаггүй бичмэл тайлангаар авч нэгтгэн гаргаж байна.

Энэ нь ГХУСТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.3-т "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах", ГХУСАЗСЗ-ийн ажиллах журмын 4 дүгээр зүйлийн 4.5-д "Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах ажлыг зохион байгуулан энэ талаар хууль сахиулах байгууллагуудтай хамтран дүн шинжилгээ хийж шалтгаан нөхцлийг нь арилгах чиглэл боловсруулж, хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна.

Иймд төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах, үйл ажиллагааны дүнд үнэлэлт, дүгнэлт хийж, гэмт хэрэг буураагүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдаагүй, хэрэгжээгүй ажлуудыг дараагийн жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу?

Бүлэг -1.3

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг жил бүр 2,079.5-34,511.0 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

ГХУС үйл ажиллагааны төсөв хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т "Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж, төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" гэж заасны дагуу төлөвлөхөөр хуульчлагдсан байна.

2015-2017 онд ГХУС үйл ажиллагааны төсөв хөрөнгийг орлогын бүрдүүлэлттэй уялдуулан төлөвлөсөн байдлыг дараах хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Он	Суурь орлого	Орлогын 40 хувь буюу төлөвлөх дүн	Төлөвлөсөн дүн	Зөрүү
1	2017	211,985.9	84,794.4	50,283.4	34,511.0
2	2016	123,449.9	49,380.0	28,661.5	20,718.5
3	2015	55,948.7	22,379.5	20,300.0	2,079.5
Нийт дүн		391,384.5	156,553.9	99,244.9	57,309.0

Хүснэгтээс харахад: 2015-2017 онд орон нутгийн орлогод 391,384.5 мянган төгрөг төвлөрсөн бөгөөд холбогдох хууль эрхийн актаар тогтоосон хувь

хэмжээгээр 156,553.9 мянган төгрөгийг ГХУС үйл ажиллагаанд зарцуулах эх үүсвэр бүрдүүлсэн боловч жил бүр 2,079.5-34,511.0 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Хуульд заагдсанаас гадна ГХУС чиглэлээр жил бүр хөтөлбөр боловсруулан аймгийн ОНХС-аас зардлыг санхүүжүүлж ирсэн байна. Тухайлбал: “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидалттай тэмцэх дэд хөтөлбөрт” 2015 онд 26,500.0 мянга, 2016 онд 10,700.0 мянга, 2017 онд “Хууль сахиулах байгууллагуудын үйлчилгээ чанарыг сайжруулж, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох хөтөлбөрт” 10,000.0 мянган төгрөгийг тус тус баталсан бөгөөд гүйцэтгэлээр 2015 онд 16,258.0 мянга, 2016 онд 2,661.5 мянга, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 1,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

1.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4-т “Төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийн шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах” гэж заасан байна.

ГХУС тухай хуулинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд зориулсан хөрөнгийг зарцуулах зардлуудыг тодорхой зааж өгсөн боловч санхүүжилтийн хэмжээг тодорхой хувиар тогтоож өгсөн нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ИТХТ-ийн 2016 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн болон ажиллах журмыг шинэчлэн баталсан байна. Уг журмын 5 дугаар зүйлд ГХУС тухай хуульд нийцүүлэн хөрөнгийг зарцуулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхой тусгаж өгсөн байна.

1.3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлын төсвийг жил бүр аймгийн ИТХ-ын тогтоолоор баталж, аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны төсөвт нэмж, зардлын нэг зүйл анги болгон хуваарилж ирсэн байна.

2015-2016 он, 2017 оны эхний хагас жилд аймгийн ГХУС үйл ажиллагааны зардалд батлагдсан төсөв, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/				
Д/д	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт /-/ Хэмнэлт +/-
1	2017	37,492.4	33,143.9	4,348.5
2	2016	28,661.5	28,661.5	0.0
3	2015	20,300.0	7,554.5	12,745.5
Нийт дүн		86,453.9	69,359.9	17,094.0

Хүснэгтээс харахад: 2015 онд батлагдсан төсвийг 12,745.5 мянган төгрөгөөр хэмнэсэн бол, 2016 онд төсвийг бүрэн зарцуулж, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 4,348.5 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

2017 онд ГХУС үйл ажиллагааны төсвийг анх 25,841.0 мянган төгрөгөөр баталсан 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, 24,442.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, аймгийн Цагдаагийн хэлтэст 24,000.0 мянган төгрөгөөр эргүүлийн автомашин худалдан авч өгч, данс бүртгэлд тусгуулсан байна.

2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд нийтдээ 69,359.9 мянган төгрөгийг зарцуулсанаас сумдад 3,797.5 мянган төгрөг буюу нийт зардлын 5.5 хувийг олгосон нь сумдад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахад төсөв хангалтгүй байна.

Иймд сумдад олгох төсвийн санхүүжилтийг оновчтой хуваарилах зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

2015-2016 он, 2017 оны эхний хагас жилийн байдлаар сумдад ГХУС чиглэлээр олгосон зардлын санхүүжилтийг хүснэгтээр харуулбал:

/мянган төгрөгөөр/

№	Сумын нэр	2017 он	2016 он	2015 он
1	Сүмбэр		800.0	550.0
2	Баянтал	870.0	200.0	
3	Шивээговь	300.0	700.0	377.5
Нийт дүн		1,170.0	1,700.0	927.5

Аудитаар 2015-2016 он, 2017 оны эхний хагас жилд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан хөрөнгийн зарцуулалтад дараах зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

1. ГХУС үйл ажиллагааны зардлаас 2015-2017 онуудад нийт 3,339.1 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Тухайлбал:
 - 2015 оны 03 дугаар сарын 24-нд Монгол улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсч хөгжсөний 94 жилийн ойг тохиолдуулан аймгийн Цэргийн штабтай хамтран “Монгол цэргийн жавхаа” арга хэмжээг зохион байгуулахад 500.0 мянга,
 - 2015 оны 05 дугаар сарын 27-нд Эх үрсийн баярыг тохиолдуулан аймгийн хэмжээнд Хүүхдийн эрхийг хамгаалах нэрийн доор насанд хүрэгчдийн дунд марафон гүйлтийн тэмцээн зохион байгуулахад 1,000.0 мянга,
 - 2015 оны 06 дугаар сарын 22-нд ажлын албаны дарга Ч.Батжаргал Улаанбаатараас-Чойр явах шатахууны зардалд 60.0 мянга,
 - 2015 онд аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны урсгал зардалд 879.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал: албан бичгийн үнэнд 59.2 мянга, самбарын үнэнд 25.0 мянга, хэвлэл зураг, өргөмжлөлийн үнэнд 620.8 мянга, шагналд 100.0 мянга, материалын үнэнд 59.1 мянга, гарын авлагын үнэнд 15.0 мянга

- 2017 оны 04 дүгээр сарын 17-нд аймгийн ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүн болон хуулийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Спортын бага наадам 2017” тэмцээнийг зохион байгуулахад 900.0 мянга,
- 2. Иргэдэд олгосон ажлын хөлс болон уралдаан тэмцээний шагналаас ХХОАТ-ын хуулийн дагуу 2015 онд 92.0 мянга, 2017 онд 45 мянга нийт 137.0 мянган төгрөгийн татвар суутган тооцоогүй байна.
- 3. 2016 оны 06 дугаар сарын 16-нд “Хувь хүний харилцаа” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар “Гэзэгт” ЗБН-д 300.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч сургалтыг зохион байгуулаагүй санхүүгийн баримтанд өмнөх онд зохион байгуулсан сургалтын бүртгэл, зураг тайланг хуулбарлан хавсаргаж, хуурамч баримт бүрдүүлсэн байна.
- 4. Олон нийтийн цагдаагийн цалин хөлс, урамшууллыг тооцож олгохдоо 276.1 мянган төгрөгийг илүү, 728.0 мянган төгрөгийг дутуу олгосон байна.
 - Олон нийтийн цагдаа Б.Батцэнгэл нь 2015 оны 02 дугаар сард цалингүй чөлөө авсан байтал 243.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон,
 - 2015 онд олон нийтийн цагдаа нарын цалинг олгохдоо тухайн сарын ажилласан өдөрт ногдуулалгүй, тогтмол 22 хоногоор тооцсоноос 5 хүнд 41.2 мянган төгрөг дутуу,
 - 2015 оны 07 дугаар сард Э.Тулгад ээлжийн амралтын цалин 16.5 мянган төгрөг илүү,
 - 2016 оны 02 дугаар сард Б.Баяржаргалд цалин 16.6 мянган төгрөг илүү,
 - 2017 оны 01 дүгээр сард Б.Хишигдалайд цалин 60.0 мянган төгрөг дутуу,
 - Нягтлан бодогч тооцооллын алдаа гаргаснаас олон нийтийн цагдаа нарын цалингаас ХХОАТ-ын хуулийн дагуу хөнгөлөлтийг эдлүүлэхдээ дутуу эдлүүлж, 2015 онд 204.7 мянга, 2016 онд 321.3 мянга, 2017 оны эхний хагас жилд 100.8 мянга, нийт 626.8 мянган илүү суутгасан байна.

Дээрх зөрчил дутагдлууд нь төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай захиран зарцуулахгүй байгааг харуулж байгаа бөгөөд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно”, 19.5-д “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэснийг тус тус зөрчсөн байна.

1.3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад хууль болон журмаар зохицуулагдсан байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5-д “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль

тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэсэн заалтаар зохицуулагдсан байна.

Мөн аймгийн ИТХТ-ийн 2016 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “ГХУСАЗСЗ-ийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1-д “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина”, 6.2-т “Зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн, хууль журмын дагуу явагдаж буй эсэхэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нар хяналт тавьж ажиллана” гэж заасан байна.

Гэтэл 2015-2017 онуудад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд хууль болон журмаар зохицуулагдсан байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн ИТХ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор камержуулах ажилд 9,849.0 хөрөнгийг зарцуулахдаа гэрээний хугацаанд ажлыг бүрэн хийж гүйцэтгээгүй, ажлыг хүлээн аваагүй зөрчил илэрч зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн боловч албан шаардлагын хэрэгжилтийг хангаагүй байна.

Аймгийн ИТХ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийг аймгийн ИТХ-ын төсөв дээр нэмж баталж байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж зарцуулна” гэж заасантай нийцэхгүй байна

Хуулийн дагуу ИТХ нь дээрх зардалд хяналт тавих зохицуулалттай байтал өмнөх онуудад уг төсвийг ИТХ-ын төсөв дээр нэмж баталж, зарцуулж ирсэн байна.

Иймд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 79 дүгээр тогтоолоор баталсан зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан төсвийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг дарга хуваарилж зарцуулна” гэсэн заалтыг оруулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар нийт 4,780.2 мянган төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс илүү, дутуу тооцсон цалин болон ХХОАТ, хуурамч баримт бүрдүүлсэн 1,284.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт бичиж, 3,339.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байна.
2. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн жил бүрйн ажлын төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр нь голлон сургалт, сурталчилгаа хийхэд чиглэгдэж, хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах ажил тогтмолжсон боловч үр дүнг тооцох асуудал дутагдалтай байна.
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг тооцох үйл явц, үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг жил бүр дутуу төлөвлөсөн, үйл ажиллагааны төсөв, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 дэх заалттай нийцээгүй, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад хууль болон журмаар зохицуулагдсан байгууллагуудаас хяналт шалгалт хийгдээгүй, хуулийн дагуу ИТХ нь хяналт тавих зохицуулалттай байтал жил бүр уг төсвийг ИТХ-ын төсөв дээр нэмж баталж, зарцуулж ирсэн байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн даргад:

1. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн жил бүрийн ажлын төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцлийг тогтоох чиглэлийн ажлуудыг тусгаж, сумдаас болон аж ахуйн нэгж, байгууллагуудаас авсан ажлын саналыг нэгтгэж, төсвийг чиг үүрэг, арга хэмжээ бүрээр нарийвчлан гаргаж, аймгийн хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлах
2. Төлөвлөгөөний биелэлтийг ханган, үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт, дүгнэлт хийж, гэмт хэрэг буураагүй, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдаагүй, тайлант онд хэрэгжээгүй ажлуудыг дараагийн жилийн төлөвлөгөөнд тусгаж ажиллах
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх арга хэмжээ авах
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсөв, санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 дэх заалттай нийцүүлэн төлөвлөх
5. ГХУСАЗСЗ нь ГХУС тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т зааснаас бусад зардлыг төлөвлөж, зарцуулахгүй байх
6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 79 дүгээр тогтоолоор баталсан зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан төсвийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг дарга хуваарилж зарцуулна” гэсэн заалтыг оруулах
7. Аймгийн ИТХ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг зөвлөлөөр хэлэлцүүлж, хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

42011 Чойр, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс: (01-542) 2-32-71

2017.10.23 № 240
танай 2017.10.20-ны № 193

Санал хүргэх тухай

АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

Х.Оюунбаатар
Саналт тайланг
түргэлж

Хүснэгт
1/2

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажлын үр дүнг тухайн оныг өмнөх оны гэмт хэргийн гаралтай харьцуулан гаргаснаар үр дүн тооцогддог. Тухайлбал аймгийн хэмжээнд гэмт хэргийн гаралтыг 2017 оны эхний 9 сарын байдлаар 2016 оны мөн үетэй харьцуулахад 10,3 хувиар буурсан нь сургалт, сурталчилгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил сайн хийгдэсний үр дүн гэж үзэж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн нь 2016 онд шинээр томилогдож 2017 оны төлөвлөгөөгөө батлан, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хурлыг 11 дүгээр сард хийхээр төлөвлөж байна.

Танай ирүүлсэн зөвлөмжинд хуулийн дагуу ИТХ нь хяналт тавих зохицуулалттай байдаг. Гэтэл жил бүр уг төсвийг ИТХ-ын төсөв дээр нэмж баталж, зарцуулж ирсэн байна гэдэгтэй санал нийлэхгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам зарим нэмэлт өөрчлөлт оруулах тухай 29 дүгээр зарилгийн "Аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөл" бүлгийн 4-ийг "Орон нутгийн салбар зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт тусгайлан санхүүжүүлж байна. Салбар зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг тухайн ИТХ, Засаг даргын Тамгын газрын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ" гэж өөрчлөлт оруулсан нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд ИТХ хяналт тавихаас гадна хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд ИТХ-д төсөв баталж зарцуулж болно гэж үзэж байна.

ДАРГА  Г.БАТЗАМ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс ирүүлсэн саналтай танилцаад дараах тайлбарыг хийж байна.

Тус зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 29 дүгээр зарлигийн 4-т “Орон нутгийн салбар зөвлөлөөс холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум дүүргийн төсөвт тусгайлан санхүүжүүлж байна. Салбар зөвлөлийн **өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг** тухайн ИТХ, Засаг даргын тамгын газрын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ” гэсний дагуу аймгийн ИТХ нь төсөв баталж, зарцуулж болно” гэсэн тайлбар ирүүлсэн байна.

Уг зарлигаар 2 өөр утга бүхий асуудлыг зохицуулсан байна. Үүнд:

1. “Орон нутгийн салбар зөвлөлөөс **холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар аймаг, нийслэл, сум дүүргийн төсөвт тусгайлан санхүүжүүлж байна” гэсэн бөгөөд энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “**Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж, зарцуулна**” гэсэн заалтаар зохицуулагдсан байна.
2. “Салбар зөвлөлийн **өдөр тутмын үйл ажиллагааны зардлыг** тухайн ИТХ, Засаг даргын тамгын газрын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ” гэсэн нь салбар зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах бичиг хэрэг гэх мэт урсгал зардлын талаар зохицуулсан боловч өдөр тутмын үйл ажиллагааны зардалд ямар, ямар зардлууд орохыг нарийвчлан заагаагүй, энэ нь хуулиар зохицуулагдаагүй байна.

Иймд аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.